

**ОРЧИН ЦАГИЙН ТҮРЭГ, МОНГОЛ ХЭЛНИЙ
ХЯЗГААРТАЙ ЧАНАР БА ХЯЗГААРГҮЙ ЧАНАР**

М.Ууганбаяр

Орчин цагийн түрэг, монгол хэлний болц цагийн хэлбэрүүдэд холбогдох болцын утга үүсэхэд хамгийн гол хүчин зүйлийн нэг нь болцын ангиуд, өөрөөр хэлбэл, хязгаартай чанар ба хязгааргүй чанар гэсэн түгээмэл болцын хослол юм (Мурясов Р.З. 2001:105-109).

А.В.Бондарко (1984:13) болцын хэлбэрүүдийн утга үйл үгийн үндэснээ байх хязгаартай ба хязгааргүй чанарын нэмэлт шинжүүдээр боджиж баяждаг гэж үзэж байна.

Ф.А.Ганиев (1963:106) татар хэлнээ үйл үгийн төгс шинж (совершенство) эс төгс шинж (несовершенство) гэх зарчмын дагуу болцоор хуваагдахгүй ба гэхдээ энэ онцлог татар хэлнээ үйл үг явдлын хязгаарт хүрч очихуйг илтгэдэггүй гэсэн үг биш болохыг үйл үгийн хязгаартай ба хязгааргүй чанар татар хэлний үйл үгнээ хам эхэд болцын утгатай шууд холбогддогийг заав. Ийнхүү дээрх утгазүй-үгийн сангийн ай төгс ба төгс бус шинжийн айгаас огт өөр бөгөөд тусгай хэлзүйн хэлбэргүй ба татар хэлний үйл үгийн хэлбэрүүдийн болцын утгын үндэс болох юм. Ф.А.Ганиев хязгаартай ба хязгааргүй чанар нь зөвхөн хэдэн хэлнээ байх болцын ай олон хэлнээ байх үйл хөдлөлийн урсах шинж (характер протекания действия) буюу байдлын (акционсарт) хооронд оршдогийг хэлжээ (1963:113-114).

Уламжлалт утгаар болцын хэл зүйн айгүй өөрөөр хэлбэл, болцын хэл зүйн хэлбэрүүд тусгай тогтолцоонд тулгуурлаагүй хэлнүүдэд хязгаартай ба хязгааргүй чанарын эсрэгцэл үйл явдлын өөрийн хязгаартай харьцах харьцааны ерөнхий тогтолцоонд чухал ач холбогдолтой юм.

Зайлшгүй бүхэл багтаамжит болцын айгүй болцын харьцаа үзүүлэгчдийн сонголттой холбоотойгоор хэрэглэгдэх орчин цагийн түрэг, монгол хэлнээ үйл үгийн үгийн сангийн утгад хамаарагдах болцын тодорхойлол нь хязгаартай ба хязгааргүй утгатай харьцах харьцааны үүрэг нэмэгддэг (Бондарко А.В. 1986:18, 1991:197; Насилов Д.М. 1984:128-165). Өөрөөр хэлбэл орчин цагийн түрэг, монгол хэлний хязгаартай ба хязгааргүй шинжийн эсрэгцэл болц чанарын орны төвийн нэг хэсэг болж байна.

Үйл үгийн утганд агуулагдах өгөгдсөн үйл явдлын уугуул шинжээр урьдаас заах хязгаарыг хязгаартай шинж гэнэ. Ерөнхийдөө үйл хөдлөлүүд өөрийн урсгалдаа энэхүү хил хязгаар тийш чиглэн энэхүү хил хязгаарыг давсан нөхцөлд дуусаж зогсох шаардлагатай болно. Алс төлөвдөө ч болов үйл хөдлөлийн урсгалыг хязгаарлах дотоод хил үгүй байхыг хязгааргүй чанар гэнэ (Маслов Ю.С. 1984:11).

Орчин цагийн түрэг, монгол хэлнээ хязгаартай үйл үгүүд тооны ялгаат тайлбараар эсвэл хязгааргүй утгат дайвар үгийн нөлөөгөөр хязгааргүй утгыг заана.

Доорх жишээнд хязгааргүй үйл үгүүд хам эхийн зүгээс өөрөөр хэлбэл тооны ялгаат тайлбараар давталтыг зааж дахин айжсаны дүнд хязгааргүй чанарыг илэрхийлнэ.

İçlerinden bazıları sofranın biraz uzağına atılmış koltuklara oturarak günlük şeylerden bu birkaç yaşın kendilerinden ayırdığı gençlerle konuşmağa bile razı oldular (АHT Aydaki kadın 73).

Тэдний дундаас зарим нь ширээнээс ялимгүй холд хаягдсан буйданд сууж өдөр тутмын зүйлсээс энэхүү хэдэн насаар өөрөөс нь ялгарах залуустай ярилцахыг хүртэл зөвшөөрцгөөв

Zeynebin çığığı üzerine koşanlar karımı güç halle ve yarı çlü olarak elimden kurtardılar (АHT Evin sahibi Abdulla Efendinin Rüyalari 156).

Зэйненийн хашигираанаар гүйх хүмүүс эхнэрийг минь хүнд байдалд хагас үхмэлээр гараас минь аварсан.

Elindeki kitaba dönünce ben o şişik mosmor gözlerin hala okuyabilmesine şaşarak orada dikilip kaldım (OP Sessiz ev, 266).

Гарт нь буй ном руу чиглэнгүүт би тэрхүү бүлцийсэн цэв цэнхэр нүд одоо ч уншиж чадаж буйг гайхаж тэнд зогсоод үлдсэн.

Ka durunca bir şey söylemeden tutulup kaldı (OP Kar, 86).

Ка зогсонгуут ямар нэг юм хэлэлгүйгээр баригдаж үлдэв.

Buraya döndükten sonraki yıllarda çocuğumuz olmadığı için beni Erzurum'a İstanbul'a doktolara götürmeye başladı (OP Kar, 40).

Наашаа буцаж ирсний дараах жилүүдэд бид хүүхэдгүй учир намайг Эрзурум Стамбулд эмчид аваачиж эхлэв.

Uzaklarda bir yerde gök gürleyince yeniden itmeye başladım (OP Sessiz ev, 230).

Би хол газар тэнгэр дуугарахад дахиад түлхэж эхэлсэн.

ОТү. razı oldular “зөвшөөрцгөөв”, kurtardılar “аврав”, ОМо. Хэлцгээсэнгүй одоцгоолоо гэхэд ерөнхий өнгөрсөн хязгаартай үйл үгүүд, ОТү. bazıları “зарим нь”, koşanlar “гүйх хүмүүс”, ОМо. Соловьев эмч сувилагч Наташа, хүмүүс гэх олон тоот өгүүлэгдэхүүн олон тооны хувиллын тооны ялгаат тайлбарын үр дүнд хязгааргүй чанарыг илтгэнэ.

ОТү. razı oldular “зөвшөөрцгөөв”, kurtardılar “аврав” зэрэг үйл үгийн тооны утгыг -lar олон тооны нөхцөл зааж, ОМо. Хэлцгээсэнгүй одоцгоолоо гэх жишээнд -цгаа олноороо үйлдэх байдлын нөхцөл нэмэгдэнэ.

ОТү. dikilip kaldım “зогсож үлдэв”, tutulup kaldı “баригдаж үлдэв” гэхэд ерөнхий өнгөрсөн хязгаартай үйл үгүүд kal- “үлд-” хос үйл үгтэй бүтцийн хоёр дахь махбодын заах хязгааргүй утгын тусламжтайгаар үйл үг хил хязгаартаа хүрээгүйг (Бангуоглу Т. 1995) илтгэнэ.

ОТү. götürmeye başladı “хүргэж эхэлсэн” itmeye başladım “түлхэж эхэлсэн” ерөнхий өнгөрсөн хязгаартай үйл үгүүд başla- “эхлэ-” хэмээх задлаг бүтцийн хоёр дахь махбодын заах хязгааргүй утгын тусламжтайгаар götür- “хүргэ-”, it- “түлх-” гэх үйл үгүүдийн хил хязгаартаа хүрч амжаагүйг эхлэх байдал эхлэлийг /ингрессив/ заана (Гузев В.Г. 1988:6). ОМо. хүрч явна ерөнхий өнгөрсөн хязгаартай үйл үг хос үйл үгт бүтцийн хоёр дахь махбод яв= гэх үйл үгийн илтгэх хязгааргүй утгын тусламжтайгаар үргэлжлэх болц (Пагва Т. 1961:35-36; Тодаева Б.Х. 1951:117-118) үйлийн хил хязгаартаа хүрч чадаагүй утгыг илтгэх ба ийнхүү хязгаартай “хүрэх” гэх үйл үг хязгааргүй “явах” гэсэн үйл үгээр саармагжина.

Доорх жишээнд хязгаартай үйл үгүүд үгийн хэрэглүүрийн нөлөөгөөр хязгааргүй чанарыг илтгэнэ

ОТү.

Hala çalan müziği sanki hiç duymadan ve kamyonlar ve otobüsleri geçtikçe kornalarımızı bomboş ve duygusuzca öttüre öttüre gittik uzun uzun gittik (OP Sessiz ev, 128)

Одоо ч эгшиглэх хөгжмийг огт сонсоогүй мэт ачааны тэрэг автобус өнгөрөх тусам дохиогоо хов хоосон мэдрэмжгүйгээр чарлуулан чарлуулан явав удаан явав.

O zamandan beri dokuz sene gecti (AHT Bir yol, Abdullah efendinin, 81)

Тэр цагаас хойш есөн жил өнгөрөв.

Karanlıkta adımlarım bütün bu eski sahipsiz eşyaya takıla takıla sofadan gelen ışıktan birden bire canlanan büyük bir aynada hiç de bana benzemeyen silik bir hayali seyir ede ede birkaç defa gidip geldim (AHT Saatleri ayarlama, 87)

Харанхуйд алхаа минь энэхүү бүх хуучин эзэнгүй хогшилд тээглэн буйдангаас ирэх гэрэлд гэнэт амьлах том толинд надтай огтхон адил бус бүдэг зүүдний юм үзэн үзэн хэд хэдэн удаа ирж буцав.

Söylemeye hacet yok ki, ben bu gusulhaneye ancak onbir yaşından sonra üç defa girdim (AHT Acibademdeki köşk, Hikayeler, 104)

Хэлэх шаардлагагүй, би энэ угаалгын өрөөнд зөвхөн арван нэгэн наснаасаа хойш гурван удаа орсон.

İster gülümsesin ister öfkелensin, lauballığımden igrensин iki üç defa daha döndüm (RHK Nilgun, 58)

Инээмсэглэсэн ч бай уурласан ч бай эрээгүй байдалд минь эгдүүцсэн ч бай хоёр гурван удаа дахин буцсан би.

Vaat ettiğim ikinci ziyareti bir turlu yapamadım konağının önünden iki defa geri döndüm (RHK Nilgün, 227)

Би амласан хоёр дахь зочлолтоо яагаад ч хийж чадаагүй байшингийнх нь урдаас хоёр удаа буцсан.

ОТү. gittik “явав” ОМо. “эхэллээ” хязгаартай ерөнхий өнгөрсөн цагийн үйл үгүүд ОТү. uzun uzun “урт урт” ОМо. өдөр хоног өнгөрөх бүр аажим аажмаар хязгааргүй дайврын бүлгийн (Бангуоглу Т. 1995:374) нөлөөгөөр ОТү. geçti “өнгөрөв” ОМо. “гарсангүй, сэрнэ, өнгөрөв” гэх хязгаартай ерөнхий өнгөрсөн цагт үйл үгүүд ОТү. ОМо. гурван жилд, зун, өвөл, нэг хоног, хоёр хоног гэх зэрэг хязгааргүй дайвар үг дайврын бүлгийн нөлөөгөөр хязгааргүй чанарыг заана. ОТү. geldim “ирлээ”, girdim “орсон”, döndüm “буцсан”, ОМо. “очлоо” хязгаартай өнгөрсөн цагт үйл үгүүд, мөн ОМо. ирнэ хязгаартай ерөнхий ирээдүй цагт үйл үг ОТү. birkaç defa “хэд хэдэн удаа”, üç defa “гурван удаа”, ОМо. “нэг хоёр удаа, хэд хэд” тэргүүтэн тоо хэмжээ заах дайвар үгээр хязгааргүй чанарыг үзүүлнэ.

Л.Йохансон (1971:198) орчин цагийн түрэг хэлэнд I. анги үглэврүүд (хязгаартай үйл үгүүд) тооны ялгаат тайлбараар (durch Quantitative Umdeutung) дахихуйг (Wiederholung) багтаасны үр дүнд хувиргалгүй үглэвэр болж шинээр айждагийг бичжээ.

Түүнчлэн Л.Йохансон dökül- “цутга-” төрлийн олон утгат үглэврүүд I. ангид хамаардгийг энд тайлбар цаг ямагт сүүлийн хуиргалтай хувиралгүй (Tf: Nf) ялгамжтай тохирдгийг зөвхөн хэлний бус мэдлэгт тулгуурласан dökül “цутга-” I +ser Nf гэх тайлбарын

хажуугаар түүнийг мэдээ гэж хүлээн зөвшөөрөгчийг Kızılırmak Karadenize dokülüyör “Улаан мөрөн Хар тэнгист цутгана” гэх өгүүлбэрт голын урсгалын ойрмогхон гарч ирэхийн урьдаас мэдээлэгч болж ойлгоход саад болдгийг бичжээ.

Л.Йохансон (1971:199) орчин цагийн түрэг хэлэнд хязгаар чанар хязгаар бус чанар болж хувирахын нэг хэрэгсэл болох тооны тайлбар жишээ болгож -edur- “*аад зогс-*”, -ip dur- “*-ж зогс-*” dur- “*зогс-*”, екоу- “*-аад тавь-*”, egel- “*-аад ир-*” зэрэг хос үйл үгт бүтцүүдийг харуулж эдгээрийн хувиргалт язгуур нь хувиргалгүйг бүтээдгийг бичээд basil “*шахагд-, дарагд-*”, basilagel- “*шахагдаж ир-, дарагдаж ир-*” гэх баримтыг заав. Түүнчлэн Yıldızlar söndü “*Одод бөхөв*” гэх жишээгээр логикийн хувьд давтахуйг дотроо багтаах sön- “*бөх-*” гэх үйл үг yıldızlar “*одод*” гэх олон тоот өгүүлэгдэхүүн дахин айжсаны үр дүнд хувирал шинжийг хувиргал бус шинж болгон өөрчилж байна.

Э.Эргуванлы-Тайланын (1996:156) үзлээр орчин цагийн түрэг хэлнээ İki saat şehri dolaştık “*Хоёр цаг хотоор тойрон явав*” гэх өгүүлбэрт шууд бус тусагдахуун тоожих ба дуусахуйн оронд энд iki гэх зорилгогүй үргэлжлэх дайвар үг байх учир тусагдахууны хэсэгчилсэн давуу байдал үүсэж нөхцөлийн байдал үйл ажиллагаа болж өөрчлөгдөн İki saat şehri dolaştık ama hala göremedigimiz çok şeyler var “*Хоёр цаг хотоор тойрон явав, гэвч одоо ч үзэж чадаагүй олон зүйл байна*” хэмээсэн утгатай болно. Зорилготой авч агшны утгат хүрэхүй байдалтай İki saatte “*хоёр цагийн дотор*” гэх хамааралт үргэлжлэх дайвар үл зохицно.

*İki saatte araba agaca çarptı.

**Хоёр цагийн дотор машин мод мөргөв.*

Үүний эсрэгээр iki saat “*хоёр цаг*” гэх зорилгогүй үргэлжлэх дайвар var- “*хүр-*” зорилготой нөхцөл байдалтай доорх жишээнд эс тохирно.

*İki saat tepeye vardık

**Хоёр цаг толгодод хүрэв.*

İki saatte “*хоёр цагийн дотор*” үргэлжлэх дайвар цаг ямагт хүрэхүйн үйл үгтэй хамт тохиолдоно. Гэхдээ иймэрхүү үргэлжлэх дайвар нөхцөл байдлын төрлийн өөрчлөлтийг шаардах ба түүнтэй хамт тайлбарлагдах эцсийн дүн рүү чиглэх үйл явц байдал хэрэгжихүйн тайлбартай байдаг.

Г.С.Дугарова (1991:80) орчин цагийн монгол хэлнээ саатах утгатай дайвар үгүүд буюу аажмаар улам бүр хэвээр гэх дайвар үгүүд *татав, богиносов* хэмээх эс дэвших утгатай үйл үгүүдийн эс чиглэсэн утгын ойлгогдох шалтгаан болдгийг эдгээр дайвар үггүйгээр ч тухайн өгүүлбэрүүдэд эс дэвших чанар хязгаар байдлыг илэрхийлж болохыг бичжээ. Жишээ нь:

Гэвч бидний нисэн буй чигт аажим аажмаар улаан туяа татав.

Моддын урт урт сүүдэр мөлхөх мэт улам бүр богиносов.

Гэтэл эргэн тойрон битүү зузаан цас хэвээр бүрхэв.

TERMINATIVITY AND ATERMINATIVITY IN MODERN TURKISH AND MONGOLIAN

The aspectual dichotomy of terminativity and aterminativity is one of the main factors in the building of aspectual meaning connected to aspectual temporal forms in modern Turkish and Mongolian. Terminativity means the limit of actions which included in the meaning of a verb. In general, actions tend to this limit in their streamline and in the case of exceeding of the limit need to be finished but aterminativity means at least in its perspective there is no any inner limit which restrict the streamline of action. In modern Turkish and Mongolian terminative verbs express aterminative meaning by quantitative different interpretation or as a influence of aterminative adverbials aterminative meaning.

Номзүй

- Бондарко А.В.** 1984. *О грамматике функционально семантических полей*. Известия Академии Наук СССР Серия литературы и языка. Том 43, №6. М.
- Бондарко А.В.** 1986. *Семантика предела*. Вопросы языкознания. №1. М.
- Бондарко А.В.** 1991. *Предельность и глагольный вид (на материале русского языка)*. Известия Академии Наук СССР Серия литературы и языка. Том 50б №3. М.
- Ганиев Ф.А.** 1963. *Видовая характеристика глаголов татарского языка*. Казань.
- Гузев В.Г.** 1988. *О категории аспектуальности на материале староанатолийско-тюркского языка*. Советская тюркология №1.
- Дугарова Г.С.** 1991. *Глагольный вид в современном монгольском языке*. Новосибирск.
- Маслов Ю.С.** 1984. *Очерки по аспектологии*. Ленинград.
- Мурясов Р.З.** 2001. *Некоторые проблемы контрастивной аспектологии*. Вопросы языкознания №5. М.
- Насилов Д.М.** 1984. *Аспектуальные значения аналитических образований и разряды глагольной лексики в узбекском языке*. Теория грамматического значения и аспектологические исследования. Ред. А.В.Бондарко. Ленинград.
- Пагва Т.** 1961. *Вспомогательные, или служебные глаголы в современном монгольском литературном языке*. Уб.
- Тодаева Б.Х.** 1951. *Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология*. М.
- Banguoğlu T.** 1995. *Türkçenin Grameri*. TDK Yay. Ankara.
- Erguvanlı-Taylan E.** 1992. *The Parameter of Aspect in Turkish*. Modern Studies in Turkish Proceedings of the 6th International Conference in Turkish Linguistics 12-14 August.
- Johanson L.** 1971. *Aspekt im Türkischen Vorstudien zu einer Beschreibung des türkeitürkischen Aspektsystems*. Uppsala.
- Uuganbayar M.** 2004. *Türkiye Türkçesi ve Halha Moğolcasında Fiil Zaman Şekilleri*. Ankara Üniversitesi Sosyal Bilimler Enstitüsü Çağdaş Türk Lehçeleri ve Edebiyatları Anabilim Dalı Yayınlanmamış Doktora Tezi Ankara.